

БАТЛАВ.

АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ОРЛОГЧ  Э.УРТНАСАНЦАХИМ САНХҮҮ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ШИНЭЧЛЭЛИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2024.11.14

Ховд хот

ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	
1	Ашиглахад энгийн ойлгомжтой тайлбар танилцуулга гарын авлагатай байх ба бусад үйлдлийн системтэй нийцтэй байх
2	Санхүүгийн мэдээлэл нь серверийн хамгаалалттай орчинд байрлаж мэдээллийн аюулгүй байдал хангагдсан байх
3	Веб технологид суурилсан байх SSL хамгаалалттай байх
4	Одоо ажиллаж буй хэрэглэгчдийн техник хангамжид зохицож ажиллах ба техник технологийн дэвшлээс үл хамааран зохицож ажиллах эсвэл өргөжүүлэх боломжтой байх
5	Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалт хамгаалалтыг өндөр түвшинд хангасан байх Програм хангамжид хэрэглэгч тус тусын эрхээр нэвтэрдэг байх
6	Няглан бодогч, няравууд хоорондоо хамааралгүй ажилладаг байх
САНХҮҮГИЙН ПРОГРАМ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	
1	Санхүүгийн програм хангамж нь Сангийн яамнаас гаргасан тусгай зөвшөөрөлтэй байх
2	Төрийн сангийн удирдлагын цахим портал системтэй холбогдож харилцах дансны зарлага, орлогын гүйлгээг татаж мөн ТАЦНСистемээс цалингийн журналын бичилт татдаг байх /харилцах дансны орлого, зарлагын гүйлгээ, төсвийн төлөвлөгөө татаж туршиж хэрэгжүүлсэн байх /
ТАЙЛАН МЭДЭЭНИЙ БҮРТГЭЛД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	
1	Санхүүгийн тайлангууд стандартын дагуу тайлангууд гаргах импорт, экспорт хийдэг байх
2	Санхүүгийн болон төсөвт тайлан мэдээг Э-тайлан Татвар, Нийгмийн даатгал, Шилэн данс, Үндэсний Аудитын газрын стаус програм бусад холбогдох системүүдэд тохирох форматын дагуу илгээдэг оруулдаг байх
3	Тухайн жилийн төлөвлөгөө гүйцэтгэлийн сар, өссөн дүнгээр харуулах
4	Өнгөрсөн оны мөнгөн гүйлгээ, орлого үр дүн, өмчийн тайлангийн гүйцэтгэлийг автоматаар татаж оруулдаг байх
5	Дотоод хяналтын хэтрэлт, хэмнэлт, өглөг авлагын насжилтыг тооцдог байх
6	Програм орсон бүх мэдээлэл EXCEL, ADOBE pdf програм руу хөрвүүлэх боломжтой байх
7	Санхүүгийн тайланг хүссэн үедээ гаргаж хэвлэж авах боломжтой байх
8	Тайлангуудыг дансаар эдийн засгийн ангиллаар задлан харуулах боломжтой байх
БАРАА МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА	
1	Бараа материал нэр төрөл бүртгэхдээ нэр код, дансны бүлэг, ангилал, хэмжих нэгж, байршил, эд хариуцагч болон зарлагын данс, нэмэлт талбаруудыг үүсгэн оруулах
2	Бараа материалын орлого, зарлага дэлгэрэнгүй, товчоо тайлангуудыг өөрийн хүссэн хэлбэрээр авдаг байх
3	Тайлан гүйлгээний бүх баримтыг хөрвүүлэх хэвлэх боломжтой байх
4	Бараа материалын модуль нь бие даан ажиллаж тайлан мэдээг гаргах боломжтой байх бөгөөд ерөнхий журнал руу шаардлагатай мэдээллээ илгээдэг байх
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА	
1	Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийн батлагдсан маягтын дагуу импортлон оруулах боломжтой байх
2	Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар боддог байх
3	Үндсэн хөрөнгийн тайланг хугацааны интервалтай хөрөнгийн олз, хөрөнгө

	данснаас хассаны гарзын гүйлгээг давхар бичилтээр хийдэг байх
4	Үндсэн хөрөнгийн тооллогын модультай байх бөгөөд тооллогын төхөөрөмж ашиглан тоолдог байх
5	Эд хариуцагчийн тайлан эзэмшигч бүрээр гарах, бүх эд хариуцагчаар гардаг байх
6	Эд хариуцагчийн бүртгэлээр хөрөнгө бүрийг QR кодоор хөтлөх боломжтой байх
7	Эд хариуцагчийн орлого, зарлагын бүртгэл дээр зөвхөн тухайн жилийн хөрөнгө харагддаг байх
8	Үндсэн хөрөнгийн модуль нь нягтлангийн үйл ажиллагаанаас үл хамааран ашиглах боломжтой байх
9	Үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх болон бууруулах хуримтлагдсан элэгдлийн залруулгыг давхар бичилтээр хялбараар шийдсэн байх
ЦАЛИНГИЙН ТООЦООНЫ СИСТЕМД ТАВИГДАХ ШААРДЛАГА	
1	Үндсэн цалин төрийн албаны холбогдох бүх нэмэгдлүүдийг бүх төрлөөр тооцох нэмэх хасах оруулах боломжтой байх
2	Цалинг бодохдоо өдрөөр болон хоногоор тооцож боддог байх
3	Урьдчилгаа хувь, томьёо, дүн зэргээр боддог байх
4	ХХАОТ хөнгөлтийн жилийн эцэст програмаас хүн бүрээр автоматаар тооцож гаргадаг байх
5	Нийгмийн даатгалын тайланг нийгмийн даатгалын сайт руу илгээдэг байх
6	Татварын тайлангууд татварын сайт руу илгээдэг байх
НИЙЛҮҮЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА	
1	Төсөвт байгууллагын програм хангамжийн зөвшөөрөлтэй байх
2	Санхүүгийн програм хангамжийг нэвтрүүлсэн туршлагатай байх / тухайн байгууллагын хэрэглэгчдээс тодруулга авна /
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА	
1	Үйлчилгээ үзүүлэх байгууллагын тоо-172
2	Үйлчилгээний баталгаат хугацаа -1-2 жил

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Д/д	Барааны нэр	Техникийн тодорхойлолт	Тоо, ширхэг
1	2	3	4
1	Сканнер Scanner A3	Smart Office S30 түүнтэй дүйцэхүйц Сканнердах хурд: Up to 30 ppm / 60 ipm Сканнердах нягтрал: 600 x 600 dpi хүртэл (ADF), (flatbed) Хуудасны хэмжээ: A4, A3	1
2	Өнгөт принтер	Canon G2020 A4, 4800x1200dpi, Refillable Ink Tank MFP Print, Scan & Copy, print, scan, copy	1
3	Процессор Dell Optiplex 7000	Үйлдлийн систем (OS: Windows 11 албан ёсны лицензтэй (64 bit) Процессор) CPU: 13 th Generation Intel Core, 2.60 GHz to 3.50 Шуурай санах ой (RAM: 16 GB, 1x16GB, DDR5, 3200MHz	5
	Дэлгэц Dell Monitor	Дэлгэц: 27 inch График Intel HD Graphics Багтаамж (M2 SSD:512 GB	5

Хянасан:

ХБТХОХэлтсийн дарга

Боловсруулсан:

ХБТХОХэлтсийн ахлах мэргэжилтэн

СТСХэлтсийн ахлах мэргэжилтэн

